

Хагас цагийн ажил эрхлэлт (PS/DPČ) ажлын карттай хүмүүст

Ажлын карт нь хөдөлмөр эрхлэх зорилгоор удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн нэг төрөл юм.

- Оршин суух зөвшөөрөлтэй байх бүх хугацаанд оршин суух зорилгоо хангах шаардлагатай (зөвшөөрөл олгосон ажлын байранд ажиллах).

Хөдөлмөр эрхлэлтийн баталгаа нь дараах зүйлсийг агуулсан хөдөлмөрийн гэрээ (PS)

ЮМ:

- Таны хийх ажлын төрөл (ажлын байр).
- Ажил эхлэх өдөр.
- Таны ажил хийх газар.
 - Хэрэв таны ажлын байр аймаг даяар бол, жишээлбэл олон ажил эрхэлж ажлын машин ашиглах бол та байнгын мэргэжлийн жолоочийн сургалтад хамрагдах шаардлагатай бөгөөд үүнд үндэслэн та мэргэжлийн жолоочийн үр чадварын гэрчилгээ авах болно. Та үүнийг өөртөө авч явах хэрэгтэй.
- Мөн хөдөлмөрийн гэрээнд ихэвчлэн тодорхой хугацаатай/хугацаагүй гэрээ (энэ нь БНЧУ-д байх хугацаатай холбоотой байж болно), түршилтын хугацаа, амралтын эрх, цалин (нийт цалин), ажлын цаг заасан байдаг.

АНХААР! ХАГАС ЦАГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БУЙ АЖЛЫН КАРТТАЙ ХҮМҮҮСИЙН САРЫН ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛС (ЦАЛИН, УРАМШУУЛАЛ) НЬ САРЫН ЦАЛИНГИЙН ДООД ХЭМЖЭЭНЭЭС ДООГУУР БАЙЖ БОЛОХГҮЙ. 7 ХОНОГТ АЖИЛЛАХ АЖЛЫН ЦАГ НЬ 15 ЦАГААС БАГА БАЙХ ЁСГҮЙ!

- *Хэрэв таны ажил олгогч таны цалингийн тодорхой хэсгийг албан ёсоор төлдөг бол та цаашид оршин суух зөвшөөрөл авах өргөдөл гаргахад шаардагдах орлогын хэмжээг нотлох боломжгүй болох эрсдэлтэй гэдгийг бүү мартаарай.*

Хөдөлмөрийн гэрээ нь үргэлж бичгээр хийгдсэн байх бөгөөд таны болон ажил олгогчийн гарын үсэг зурсан 2 эх хувь байх ёстой. Нэг PS ажил олгогчид, нэг нь танд зориулагдана. Ажлын гэрээгээ хадгалж, хэнд ч бүү өгөөрэй!

Хэрэв та ажил олгогчийг солихыг хүсвэл:

- Та эхлээд БНЧУ-ын Дотоод хэргийн яаманд (Орогнол, цагаачлалын бодлогын газар) **тусгай маягт** өөрчлөлт оруулах тухай мэдэгдлийг (шаардлагатай бичиг баримтыг хавсаргасан) **өгөх ёстой.**
 - Та хөдөлмөрийн гэрээг дуусгавар болсон өдрөөс хойш **60 хоногийн дотор мэдэгдэл өгөх ёстой.** Ажилгүй үедээ эрүүл мэндийн даатгал төлөх ёстой гэдгийг битгий мартаарай.
- БНЧУ-ын ДХ яам өөрчлөлтийг зөвшөөрсөн эсвэл зөвшөөрөхгүй байгаа тухай мэдэгдлийг хүргэх:
 - Хэрэв ажил олгогчийг солихыг зөвшөөрвөл та шинэ ажил олгогчид ажиллаж эхлэх боломжтой.
 - Хэрэв өөрчлөлтийг зөвшөөрөөгүй бол мэдэгдлийг ирүүлээгүй гэж үздэг бөгөөд энэ нь та шинэ ажил олгогчид ажиллаж эхлэх боломжгүй гэсэн үг юм!



Spolufinancováno
Evropskou unií



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY



Projekt "Centrum na podporu integrace
cizinců v Ústeckém kraji" reg.
č. CZ.12.01.02/00/23_008/0000008 je
financován OP AMIF a MV ČR.